



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 06 дугаар
сарын 27 -ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

Хөтөлбөрт болон төсвийн хуваарьт нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.7, 28 дугаар зүйлийн 28.8.2, Засгийн газрын 2011 оны “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.7 тус тус үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс ТОГТООХ нь:


1. “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн 4.2-ын “...үйлчилгээ” гэснийг хасах, “3.0 хүртэл сая төгрөг” гэснийг “...5.0 хүртэл сая төгрөг” гэж, 4.4-ийн “...24 сарын дотор” гэснийг “36 сарын дотор” гэж, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн 2.2.1-ийн “...15-39 насны” гэснийг “18-45 насны” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны төсвийн хуваарийн нэмэлт, өөрчлөлтийн саналыг хавсралтаар баталж, хуваарийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад батлуулахаар зөвлөмж болгосугай.

3. МАОЭНХ-оос “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн дэмжлэгтэйгээр боловсруулсан “Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн стратеги”, “Үндэсний зөвлөлийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлт”-ийн төслүүдийг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хуулийн шинэчилсэн найрууллага”-д тусгахыг, үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн чиглэл, ажлаа тайлагнах журам, хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд үнэлгээ хийх журам, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг хавсралтаар баталж, хэрэгжилтийг зохион байгуулахыг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн ажлын алба /П.Хишигжаргал/-д үүрэг болгосугай.

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,
САЙД  С.ЧИНЗОРИГ



Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн
дарга  Д.ХАДХҮҮ

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн
3 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН 2018 ОНЫ ТӨСВИЙН
ШИНЭЧИЛСЭН ХУВААРИЙН САНАЛ**

/мян.төг/

№	Үзүүлэлт	2018 оны төлөвлөгөө		Өөрчлөлт	
		хүн	Хөрөнгө	Хөрөнгө	
1	Улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө		3,850,000.0		
2	Орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө				
3	Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж				
4	Гадаадын иргэдийн ажлын байрны төлбөрийн орлого		47,984,000.0		
5	ХБИ ажиллууллаагүйн төлбөрийн орлого		400,000.0		
6	Жижиг зээлийн эргэн төлөлт		11,000,000.0		
7	Жижиг зээлийн хүү, алданги				
8	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт				
9	Бусад				
10	Өмнөх оны үлдэгдэл		2,114,000.0		
Орлогын нийт дүн			65,348,000.0		
1	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх	Ганцаарчилсан зөвлөгөө	30300		
		Бүлгийн зөвлөгөө	64800	752,400.0	
2	Ажилд зуучлах үйлчилгээ	40000	758,200.0		
3	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ	4040	181,800.0	
		Үйлдвэрлэл дээрх сургалт	720	504,000.0	
		Мэргэжлийн болон давтан сургалт	2180	501,400.0	
		Дүн	6940	1,187,200.0	
4	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Санхүүгийн дэмжлэг	1718	5,154,000.0	
		Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт	5520	165,600.0	
		Борлуулалтын дэмжлэг		226,800.0	
		Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт	596	312,000.0	
		Ажил олгогчид олгох дэмжлэг	350	1,008,000.0	
		Нийтийг хамарсан ажил	10720	3,001,600.0	
		Цагийн ажилд зуучлах	15830	110,810.0	
		Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах	2000	1,000,000.0	
		Дүн	36734	10,978,810.0	
5	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	Гарааны бизнесийг хөгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах	30	300,000.0	
		Гарааны бизнесийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	144	1,440,000.0	
		Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	435	1,305,000.0	
		Борлуулалтын дэмжлэг		226,800.0	
		Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт	390	208,800.0	
		Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт	2760	82,800.0	
		Дүн	3759	3,563,400.0	
6	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Малчин өрхийг малжуулах /100 хувь эргэн төлөгдөх/	1120	5,600,000.0	
		Мал аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт	2240	280,000.0	
		Дүн	3360	5,880,000.0	
		Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ	780	54,600.0	
		Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээ	130	54,600.0	

7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	420	2,100,000.0	
		Борлуулалтын дэмжлэг		226,800.0	
		Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт	174	94,320.0	
		Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт	2800	84,000.0	
		Хөдөлмөр эрхлэлтийн сургалт	600	174,000.0	
		Ажил олгогчийн урамшуулал	174	501,120.0	
		Ажил олгогчид санхүүгийн дэмжлэг олгох	234	1,170,000.0	
		Дүн	5312	4,459,440.0	
8	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	1032	866,880.0	
		Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	180	540,000.0	
		Дүн	1212	1,406,880.0	
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн дүн			57317	28,986,330.0	
9	Жижиг зээл	4000	22,900,000.0		
10	Хүүгийн хөнгөлөлт	400	140,000.0		
11	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах		100,000.0		
12	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих		198,000.0		
13	Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, үндсэн эрхийн хэрэгжилт		250,000.0		
14	Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сан, бүртгэл, мэдээллийн сүлжээг бүрдүүлэх, ажиллуулах		780,000.0		
15	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажилтнуудын чадавхи бэхжүүлэх сургалт		400,000.0		
16	Сурталчилгаа, олон нийтийн арга хэмжээ, хөдөлмөрийн яармаг, өдөрлөг зохион байгуулах		750,000.0		
17	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хяналт, шинжилгээ,		223,670.0	+75,000.0	
18	Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа		220,000.0		
19	Гарын авлага, хэвлэмэл материал бэлтгэх, хэвлүүлэх		250,000.0		
20	Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн санхүүжилт		4,000,000.0	+2,900,000.0	
21	ХЭҮЗ-ийн шийдвэрээр тодорхойлсон бусад төслийн санхүүжилт		350,000.0		
22	Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Ажиллах хүчний шилжих хөдөлгөөний тухай хуулийг шинэчлэх судалгаа, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах төсөл, арга хэмжээ		500,000.0		
23	Зохион байгуулалттай ажлын байр бий болгох зорилтот төслийн санхүүжилт		500,000.0		
24	Налайх дүүрэгт гар аргаар нүүрс олборлож буй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн санхүүжилт		300,000.0		
25	Гэрээт малчин төслийн санхүүжилт		500,000.0		
26	Хөдөлмөр эрхлэх хүсэл, сонирхлыг нэмэгдүүлэх, нийгэмд чиглэсэн контентын санхүүжилт		150,000.0	-75,000.0	
27	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл /Улсын төсвийн орлогоос санхүүжих/		3,850,000.0	-3,400,000.0	
Зарлагын нийт дүн			61717	65,348,000.0	-



Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн
3 дугаар тогтоолын гуривдугаар хавсралт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд

Үр дүн	Хүрэх түвшин			
	Одоогийн түвшин 2018	2019	2020	2021
Нэг. Ерөнхий үзүүлэлтүүд				
1. Ажилгүйдлийн түвшин				
Үүний дотор:				
-Эрэгтэйчүүдийн				
-Эмэгтэйчүүдийн				
1.1. 15-24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин				
Үүний дотор:				
-Эрэгтэйчүүдийн				
-Эмэгтэйчүүдийн				
1.2. 25-34 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин				
Үүний дотор:				
-Эрэгтэйчүүдийн				
-Эмэгтэйчүүдийн				
2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тогтвортой байдал (ХЭДС-ийн орлогын нийт дүнд гадаад ажиллагчид ажиллуулсны төлбөрийн эзлэх хувийн бууралт)				
3. ДНБ-д Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарлагын эзлэх хувь				
4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогод орон нутгийн төсвөөс оруулсан орлогын эзлэх хувь				
Хоёр. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний чанар, үр өгөөж				
5. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ				
6. Хөдөлмөр эрхлэлтийн сургалтын үлгэрчилсэн хөтөлбөрийн тоо				
7. Үйлдвэрлэл дээр сургалт зохион байгуулдаг аж ахуйн нэгжийн тоо				

8. Орон нутгийн хөдөлмөрийн зэх зээлийн эрэлт, нийлүүлэлт, тэдгээрийн тоон болон чанарын зөрүүг судалдаг аймаг, дүүргийн тоо				
9. Ажилд зуучлагдсан хүний тоо				
10. МСҮТ, политехник коллеж төгсөгчдийн дунд мэргэжлээрээ ажиллаж байгаа хүний эзлэх хувь				
11. Их, дээд сургууль төгсөгчдийн дунд мэргэжлээрээ ажиллаж байгаа хүний эзлэх хувь				
Гурав. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн чанар, үр өгөөж				
12. Буцалтгүй олгох санхүүгийн дэмжлэгийн төрөл, тоо				
13. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажиллагааны хүрээнд экспортод гаргасан бүтээгдэхүүний тоо				
14. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажиллагааны хүрээнд үйлдвэрлэж буй импорт орлох бүтээгдэхүүний тоо				
15. Гарааны бизнесийн тоо				
16. Малжуулах арга хэмжээнд хамрагдаж амьжиргаа нь дээшилсэн малчдын тоо				
17. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрны тоо (Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр заалтын дагуу)				
18. Жижиг зээлийн хүрээнд бий болсон бодит ажлын байрны тоо				
Дөрөв. Орон нутгийн онцлог тохирсон хөтөлбөр				
19. Орон нутгийн онцлог тохирсон хөтөлбөрийн тоо				
20. Орон нутгийн онцлог тохирсон хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд бий болсон бодит ажлын байрны тоо				
Тав. ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлж буй хөтөлбөр				
21. ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлж буй хөтөлбөрийн тоо				
22. ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлсэн хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд бий болсон бодит ажлын байрны тоо				

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн
3 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28.8.3-д заасан "... хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд хийсэн хөндлөнгийн байгууллагын хяналт, шинжилгээ, үнэлгээний тайланг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах, шаардлагатай асуудлыг холбогдох байгууллагад оруулж шийдвэрлүүлэх" бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Хөндлөнгийн үнэлгээний зорилго нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.

Хоёр. Хөндлөнгийн үнэлгээ хийлгэх зарчим, хамрах хүрээ

2.1. Хөндлөнгийн үнэлгээ хийлгэхэд дараах зарчмыг баримтална:

2.1.1. Үнэлгээ хийх байгууллагыг сонгох ажиллагаа ил тод, нээлттэй, хараат бус байх;

2.1.2. Төр-хувийн хэвшлийн түншлэлийн зарчмыг баримтлах;

2.1.3. Үнэлгээний үйл ажиллагаа мэргэжлийн, нээлттэй, ил тод байх;

2.1.4. Үнэлгээг тогтмол, тодорхой үе шаттай хийх.

2.2. Үнэлгээ нь дараах хүрээг хамарна:

2.2.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих гурван талт зарчим, институци, засаглалын асуудлууд;

2.2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлого, салбар хоорондын зохицуулалт;

2.2.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт;

2.2.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр, бусад арга хэрэгсэл.

2.2.5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаан дахь төр-хувийн хэвшлийн түншлэл;

2.2.6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд үйлдвэрчний эвлэлүүд, ТББ-ын оролцоо;

2.2.7. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө.

Гурав. Хөндлөнгийн үнэлгээ хийх байгууллагыг сонгох ажиллагаа

3.1. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл нь хөндлөнгийн үнэлгээ хийх байгууллагыг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулна.

3.2. Ажлын хэсэг нь хөндлөнгийн үнэлгээ хийх байгууллагыг батлуулах саналаа Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлд оруулна.

3.3. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн хурлын шийдвэрээр гүйцэтгэгчийг сонгоно.

3.4. Хөндлөнгийн үнэлгээ хийх байгууллагатай Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн ажлын алба гэрээ байгуулна.

Дөрөв. Хөндлөнгийн үнэлгээний давтамж

4.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд хийх хөндлөнгийн үнэлгээг 2 жил тутам хийлгэнэ.

Тав. Хөндлөнгийн үнэлгээ хийх ажлын санхүүжилт

5.1. Хөндлөнгийн үнэлгээ хийх ажлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.

5.2. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тухайн жилийн төсөвт хөндлөнгийн үнэлгээ хийхтэй холбогдсон зардлыг тусгаж батална.

Зургаа. Хөндлөнгийн үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх

6.1. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл болон Засгийн газар, нийгмийн түншлэгч талууд нь үнэлгээний тайланд дурдсан зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн, олон нийтэд мэдээлнэ.

Долоо. Хариуцлага

7.1. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл нь үнэлгээний тайланд дурдсан зөвлөмж, дүгнэлтийн дагуу холбогдох албан тушаалтанд арга хэмжээ авах саналыг тухайн байгууллагад нь тавьж шийдвэрлүүлнэ.



Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн
3 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн гишүүдийн хариуцах ажил үүргийн чиглэл

Гишүүд	Байгууллага	Гишүүдийн хариуцах ажлын чиглэл
Хөдөлмөр нийгмийн хамгаалын сайд	ХЭҮЗ –ийн дарга, Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн сайд	<ul style="list-style-type: none"> - Хөдөлмөр эрхлэлтийн талаарх төрийн бодлого томъёолох - Эрх зүйн орчин боловсронгуй болгох асуудлыг шийдвэрлүүлэх - ХЭҮЗ-ийн өөрийгөө удирдах үйл ажиллагааг хангах - ХЭҮЗ-ийн гадаад хамтын ажиллагааг тодорхойлон төлөөлөх - ХЭД хүрээнд хэрэгжиж буй гадаадын төсөл, хөтөлбөрүүдийн уялдааг хангах, хяналт, үнэлгээг зохион байгуулах - Үндэсний зөвлөлийг даргалах - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого бүрдүүлэх - ХЭД-ийн үйл ажиллагаанд хяналт тавих
Ажил олгогч ажилтны байгууллагын дэд дарга 2 жилээр ээлжлэх	ХЭҮЗ-ийн дэд дарга	<ul style="list-style-type: none"> - Хөдөлмөр эрхлэлтийн талаарх төрийн бодлогод нөлөөлөх - ХЭҮЗ-ийн стратегийн баримт бичгийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнг үнэлэх ажлыг зохион байгуулах - Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлүүдийг удирдлагаар хангах - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого бүрдүүлэхэд нөлөөлөх
Төрийн төлөөлөл Сангийн болон боловсролын асуудал эрхлэсэн төрийн захиргааны төв байгууллагаас	ХЭҮЗ-ийн гишүүн Төрийн байгууллагын төлөөлөл	<ul style="list-style-type: none"> - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого, зарлагад хяналт тавих - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд улсын төсвөөс орлого оруулах - Өгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүй тохиолдолд холбогдох ажил олгогчдоор зохих төлбөр төлүүлэх ажлыг зохион байгуулах - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, ажиллах хүч гадаадад гаргах тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, - Хөдөлмөр эрхлэлтийн талаар төрийн бодлого, хууль тогтоомж, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах, эрчимжүүлэх талаар санал боловсруулах, хэлэлцүүлэх

		<p>-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг санаачлан хэрэгжүүлэх</p> <p>- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээлэл болон үйл ажиллагааны явц, үр дүнд хийсэн үнэлгээний тайланг хэлэлцэж санал дүгнэлт гаргах</p> <p>- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжиж буй гадаад, дотоодын төсөл хөтөлбөрүүдийн хяналт, үнэлгээ, хийх, үр дүнг ХЭҮЗ-ийн хуралд оруулж хэлэлцүүлэх</p> <p>- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийг бүрдүүлэх, хуваарилах асуудлыг хэлэлцэж зөвлөмж гаргах, тус сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавьж, санхүүгийн тайланг хагас, аудитын дүгнэлтийг бүтэн жилээр хэлэлцэх, санал дүгнэлт гаргах /аудит/</p> <p>- ХЭҮЗ-ийг ээлжит бусаар хуралдуулах талаар санал гаргах</p> <p>-Төлөөлж буй байгууллагадаа ажлаа тайлагнах</p>
<p>Ажил олгогчдын төлөөлөл</p>	<p>ХЭҮЗ-ийн гишүүн Ажил олгогчдын байгууллагын төлөөлөл</p>	<p>- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого, зарлагад хяналт тавих</p> <p>-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг ажил олгогчидтой хамтран санаачлан хэрэгжүүлэх</p> <p>- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, ажиллах хүч гадаадад гаргах тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих,</p> <p>- Хөдөлмөр эрхлэлтийн талаар төрийн бодлого, хууль тогтоомж, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах, эрчимжүүлэх талаар санал боловсруулах, хэлэлцүүлэх</p> <p>- ХЭҮЗ-ийг ээлжит бусаар хуралдуулах талаар санал гаргах</p> <p>- Мэргэжлийн холбоодыг ХЭД үйл ажиллагаанд татан оролцуулах ажлыг зохион байгуулах</p> <p>- ХЭҮЗ-ийн үйл ажиллагаанд нийгмийн зөвшилцөл, ТХХТ-ийг хангах</p> <p>- ХЭД үйл ажиллагааг жижиг дунд үйлдвэрлэл, их дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаатай уялдуулах, холбогдох зөвлөл, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах</p> <p>- ХЭД үйл ажиллагааны хүрээнд ажил олгогчид, аж ахуйн нэгжийн гаргасан үүсгэл санаачлагыг дэмжих, хувийн хэвшлийн оролцоог өргөжүүлэх,</p> <p>- Хувийн хэвшлийн хандивын тогтолцоог дэмжин хөгжүүлэх</p> <p>- Аж ахуйн нэгжийн ажил олгогч эзэн, удирдлагын ХЭД үйл ажиллагааны талаарх ойлголт хандлагыг дээшлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах</p>

		<ul style="list-style-type: none"> - ХЭД чиглэлээр хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт, шинжилгээ хийх, үнэлэлт өгөх, - Тэргүүлэх салбар дахь хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг тооцох, холбогдох мэдээллээр ХЭҮЗ-ийг хангах - Төлөөлж буй байгууллагадаа ажлаа тайлагнах
<p>Ажилтны төлөөлөл</p>	<p>ХЭҮЗ-ийн гишүүн Ажилтны байгууллагын төлөөлөл</p>	<ul style="list-style-type: none"> - Хөдөлмөр эрхлэлтийн талаар үйлдвэрчний эвлэлүүдээс баримтлах бодлого, байр суурийг тодорхойлох, -Хөдөлмөр эрхлэлтийн талаарх төрийн бодлогод нөлөөлөх, -Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого зарлагад хяналт тавих - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, ажиллах хүч гадаадад гаргах тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих - Хөдөлмөр эрхлэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах, эрчимжүүлэх талаар санал боловсруулах, хэлэлцүүлэх - ХЭҮЗ-ийг ээлжит бусаар хуралдуулах талаар санал гаргах - ХЭҮЗ-ийн үйл ажиллагаанд нийгмийн зөвшилцөл хангах - ХЭД үйл ажиллагааны хүрээнд иргэдийн гаргасан үүсгэл санаачлагыг дэмжих - ХЭД чиглэлээр хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилтэд олон нийтийн хяналт тавих - Тэргүүлэх салбар дахь хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлтийг тооцох, холбогдох мэдээллээр ХЭҮЗ-ийг хангах - Төлөөлж буй байгууллагадаа ажлаа тайлагнах
<p>Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн ийн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл</p>	<p>ХЭҮЗ-ийн нарийн бичгийн дарга, Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн газрын хариуцсан мэргэжилтэн</p>	<ul style="list-style-type: none"> - Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлд төлөөлөл бүхий байгуулагуудын холбогдох газар, хэлтэстэй хамтран ажлын албаны үүргийг гүйцэтгэж ажлын үр дүн, явцыг тайлагнах, тасралтгүй хэвийн ажиллах нөхцлийг хангах - Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн төсөв, жилийн ажлын төлөвлөгөөний болон үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэх, танилцуулах баримт бичгийн төслийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлд төлөөлөл бүхий байгуулагуудын холбогдох газар, хэлтэстэй хамтран бэлтгэх -Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнг үнэлэх ажлын бэлтгэл хангах -Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн үйл ажиллагааны тайланг нэгтгэн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлд танилцуулах, арга зүйн удирдлагаар хангах



Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн
3 дугаар тогтоолын тусгаар хавсралт

Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн гишүүдийн хариуцах ажил үүргийн чиглэл

Гишүүд	Төлөөлж байгаа байгууллагын нэр	Хариуцах ажлын чиглэл
<p>Төрийн төлөөлөл, Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн дарга</p>	<p>Аймаг (нийслэл, дүүрэг)-ийн Засаг дарга/ Засаг даргын орлогч</p>	<ul style="list-style-type: none"> - Зөвлөлийн өөрийгөө удирдах үйл ажиллагааг хангах; - Хөдөлмөр эрхлэлтийн талаар аймаг (нийслэл, дүүрэг)-ийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас орон нутагт хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөр боловсруулж, бодлогын шийдвэр гаргуулах, хэрэгжүүлэх ажлыг удирдах; - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд төвлөрлийг сааруулах чиглэлээр төсөл, хөтөлбөр санаачилж, төрийн бодлогод тусгуулах; - Зөвлөлийн гадаад хамтын ажиллагааг тодорхойлон төлөөлөх; - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилах асуудлыг шийдвэрлүүлэх; - Тухайн орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийг зохицуулах асуудлыг шийдвэрлүүлэх; - Аймаг (нийслэл, дүүрэг)-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны тухай мэдээлэл, явц, үр дүнд хийсэн хяналт шинжилгээ, хөндлөнгийн үнэлгээний тайланг хэлэлцүүлж санал дүгнэлт гаргах; - Орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, ажиллах хүч гадаадад гаргах тухай хууль тогтоомж хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавих, зохих арга хэмжээ авах; - Тухайн орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд орон нутгийн бүхий л шатны төрийн байгууллагыг татан оролцуулах; - Зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг хангуулах, талуудаас ирүүлсэн саналын дагуу хэлэлцэх асуудлыг бэлтгүүлэх; - Зөвлөлийн тогтвортой ажиллагааг хангах; - Зөвлөлийн гишүүд төлөөллийн байгуулагадаа ажлаа тайлагнах болон зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдсон бусад асуудлыг аймаг (нийслэл, дүүрэг)-ийн хөдөлмөр нийгмийн зөвшлийн хэлэлцээрт тусгах, хэрэгжилтэд хяналт тавих;

		<p>- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн гаргасан үүсгэл санаачлагыг дэмжих;</p> <p>-Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн сайдад болон тухайн орон нутгийн ИТХ-д хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хийсэн ажлаа тайлагнах;</p> <p>-Зөвлөлийн хуралдааныг даргалах, үйл ажиллагааг нь удирдах.</p>
<p>Төрийн телеөлөл</p>	<p>Нийгмийн бодлого, хөгжлийн асуудал эрхэлсэн хэлтэс, төрийн сангийн хэлтэс</p>	<p>- Зөвлөлийн өөрийгөө удирдах үйл ажиллагааг хангах;</p> <p>-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн орлого, зарлагад тавих төрийн хяналтыг хэрэгжүүлэх;</p> <p>-Орон нутагт хэрэгжиж буй хөдөлмөр эрхлэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах, эрчимжүүлэх талаар санал боловсруулах, хэлэлцүүлэх;</p> <p>-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээний тухай саналыг үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн хэлтэстэй хамтран бэлтгэж зөвлөлийн хуралд оруулж хэлэлцүүлэх;</p> <p>-Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох ажлыг дэмжин зохион байгуулах;</p> <p>-Аймаг (нийслэл, дүүрэг)-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны тухай мэдээлэл, явц, үр дүнд хийх хяналт шинжилгээ, хөндлөнгийн үнэлгээний тайлан гаргах ажлыг зохион байгуулах, бэлтгүүлэх;</p> <p>-Тухайн орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийг зохицуулсан тухай тайлан бэлтгэж зөвлөлийн хуралд оруулж хэлэлцүүлэх;</p> <p>-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн орлого бүрдүүлэх, орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилах санал бэлтгэж, санхүүгийн болон аудитын тайлан, дүгнэлтийг зохих хугацаанд хэлэлцүүлэх;</p> <p>-Зөвлөлийн төсөв зардал, хангамжийн талаар болон дэд сангийн санхүүгийн бие даасан байдлыг хангах талаар дүгнэлт, зөвлөмж өгөх;</p> <p>-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд орон нутгийн нийгмийн хөгжил, төрийн сан хариуцсан төрийн байгууллагыг татан оролцуулах;</p> <p>-Зөвлөлийн ээлжит бус хуралдаан хийх санал гаргах;</p> <p>- Аймаг (нийслэл, дүүрэг)-ийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хийсэн ажлаа тайлагнах;</p> <p>- Зөвлөлийн бусад гишүүдтэй хамтран иргэдэд ажлаа тайлагнах.</p>
		<p>-Зөвлөлийн өөрийгөө удирдах үйл ажиллагааг хангах;</p> <p>-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулах</p>

<p>Ажил олгогчдын төлөөлөл</p>	<p>Аймаг (нийслэл, дүүрэг)-ийн ажил олгогч, ажил олгогч эздийн холбоо</p>	<p>арга хэмжээг ажил олгогчидтой хамтран санаачлан хэрэгжүүлэх; -Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ эрхэлсэн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын хамтын ажиллагааг дэмжих; -Зөвлөлийн ээлжит бус хуралдаан хийх санал гаргах; -Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар мэргэжлийн холбоод, ажил олгогчдоос гаргасан үүсгэл санаачлага, хандивын тогтолцоог дэмжин хөгжүүлэх; -Зөвлөлийн үйл ажиллагаанд төр-хувийн хэвшлийн түншлэлийн арга хэрэгсэл нэвтрүүлэх ажлыг санаачлах, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ эрхэлсэн төрийн байгууллага, ажил олгогч гэрээний үндсэн дээр хамтран ажиллахыг дэмжих; -Аймаг (нийслэл, дүүрэг)-ийн мэргэжлийн боловсрол, сургалтын болон жижиг, дунд үйлдвэрийн зөвлөлтэй хамтран ажиллах ажлыг зохион байгуулах; -Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, ажиллах хүч гадаадад гаргах тухай хууль тогтоомжийн талаарх ажил олгогч эзэн, менежерүүдийн ойлголт хандлагыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах, хууль тогтоомжид заасан үүргийнх нь биелэлтийг хангах талаар зөвлөлгөө, мэдээлэл өгөх; -Хүний нөөцийн богино, дунд хугацааны эрэлт хэрэгцээг тооцож төлөвлөх талаар ажил олгогч эзэн, менежерүүдийн сургалт зохион байгуулах; - Орон нутгийн ажил олгогчид, тэдгээрийн холбоонд ажлаа тайлагнах. - Зөвлөлийн өөрийгөө удирдах үйл ажиллагааг хангах; -Зөвлөлийн удирдах, хянах үүргийн хэрэгжилтэд үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах; - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого, зарлагын гүйцэтгэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, ажиллах хүч гадаадад гаргах тухай хууль тогтоомжийн биелэлт, төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд олон нийтийн хяналт тавих; - Хөдөлмөр эрхлэлтийн талаар үйлдвэрчний эвлэлүүдээс баримталж байгаа бодлого, байр суурийг хэрэгжүүлэх; -Хөдөлмөр эрхлэлтийн талаарх төрийн бодлогод нөлөөлөх хүрээнд хууль тогтоомж, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах, эрчимжүүлэх талаар санал боловсруулах, хэлэлцүүлэх; -Зөвлөлийн ээлжит бус хуралдаан хийх санал гаргах; -Орон нутгийн үйлдвэрчний эвлэл, ажигтнуудыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажиллагаанд татан оролцуулах ажлыг зохион байгуулах, иргэдийн үүсгэл санаачлагыг дэмжих; - Иргэд болон аймаг (нийслэл, дүүрэг)-ийн үйлдвэрчний эвлэлийн холбоонд ажлаа тайлагнах.</p>
<p>Ажилтны төлөөлөл</p>	<p>Аймаг (нийслэл, дүүрэг)-ийн үйлдвэрчний эвлэлийн холбоо</p>	<p>арга хэмжээг ажил олгогчидтой хамтран санаачлан хэрэгжүүлэх; -Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ эрхэлсэн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын хамтын ажиллагааг дэмжих; -Зөвлөлийн ээлжит бус хуралдаан хийх санал гаргах; -Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар мэргэжлийн холбоод, ажил олгогчдоос гаргасан үүсгэл санаачлага, хандивын тогтолцоог дэмжин хөгжүүлэх; -Зөвлөлийн үйл ажиллагаанд төр-хувийн хэвшлийн түншлэлийн арга хэрэгсэл нэвтрүүлэх ажлыг санаачлах, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ эрхэлсэн төрийн байгууллага, ажил олгогч гэрээний үндсэн дээр хамтран ажиллахыг дэмжих; -Аймаг (нийслэл, дүүрэг)-ийн мэргэжлийн боловсрол, сургалтын болон жижиг, дунд үйлдвэрийн зөвлөлтэй хамтран ажиллах ажлыг зохион байгуулах; -Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, ажиллах хүч гадаадад гаргах тухай хууль тогтоомжийн талаарх ажил олгогч эзэн, менежерүүдийн ойлголт хандлагыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах, хууль тогтоомжид заасан үүргийнх нь биелэлтийг хангах талаар зөвлөлгөө, мэдээлэл өгөх; -Хүний нөөцийн богино, дунд хугацааны эрэлт хэрэгцээг тооцож төлөвлөх талаар ажил олгогч эзэн, менежерүүдийн сургалт зохион байгуулах; - Орон нутгийн ажил олгогчид, тэдгээрийн холбоонд ажлаа тайлагнах. - Зөвлөлийн өөрийгөө удирдах үйл ажиллагааг хангах; -Зөвлөлийн удирдах, хянах үүргийн хэрэгжилтэд үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах; - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого, зарлагын гүйцэтгэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, ажиллах хүч гадаадад гаргах тухай хууль тогтоомжийн биелэлт, төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд олон нийтийн хяналт тавих; - Хөдөлмөр эрхлэлтийн талаар үйлдвэрчний эвлэлүүдээс баримталж байгаа бодлого, байр суурийг хэрэгжүүлэх; -Хөдөлмөр эрхлэлтийн талаарх төрийн бодлогод нөлөөлөх хүрээнд хууль тогтоомж, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах, эрчимжүүлэх талаар санал боловсруулах, хэлэлцүүлэх; -Зөвлөлийн ээлжит бус хуралдаан хийх санал гаргах; -Орон нутгийн үйлдвэрчний эвлэл, ажигтнуудыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажиллагаанд татан оролцуулах ажлыг зохион байгуулах, иргэдийн үүсгэл санаачлагыг дэмжих; - Иргэд болон аймаг (нийслэл, дүүрэг)-ийн үйлдвэрчний эвлэлийн холбоонд ажлаа тайлагнах.</p>